



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аймаг, сумдын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаж, гэрээ байгуулсан нийт төсөл, арга хэмжээний 90.2 хувь нь бүрэн хэрэгжсэн байна.

АУДИТЫН СЭДЭВ: ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2025 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: СЭА-2026/05-17-ШТА-НА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Сүхбаатар сум

2026.05.08

Дарга, тэргүүлэх аудитор Б.Батмөнх

Утас: 70363040, Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn

Ахлах аудитор Ц.Отгонбаяр

Утас: 70363036, Цахим хаяг: Otgonbayarts@audit.gov.mn

Ахлах аудитор С.Баасансүрэн

Утас: 70362442, Цахим хаяг: Baasansurens@audit.gov.com

Аудитор Ж.Баясгалан

Утас: 70362442, Цахим хаяг: Bayasgalanj@audit.gov.mn

Аудитор Р.Отгонжаргал

Утас: 70362442, Цахим хаяг: Otgonjargalr@audit.gov.mn

Товчилсон үгийн тайлбар	2
Хүснэгтийн товьёг	2
Дүрслэлийн товьёг	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	3
Ерөнхий мэдээлэл	4
1 дүгээр бүлэг: Захиалагч нь ажлын зураг, төсөв боловсруулах даалгаврыг батлаагүйгээс техникийн шаардлага тодорхой бус болох, зураг төсөвт өөрчлөлт орох, төсөвт өртөг нэмэгдэх, чанар, үр ашиг буурах эрсдэлийг дагуулж байна	6
1.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 91.0 хувийг аймаг, сумдын хөгжлийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан төлөвлөсөн байна	6
1.2 Шатны шатны захиалагч нь ОНХО-ын төсөл, арга хэмжээний зураг, төсөв боловсруулах ажлын даалгаврыг боловсруулж, батлаагүй байна.	9
2 дугаар бүлэг: Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулсан байна.	13
2.1 Зураг төсөв, техникийн тодорхойлолтыг боловсруулаагүйгээс шалтгаалан 4 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй байна.	13
2.2 Тайлант онд тендер шалгаруулалттай холбоотой 6 аж ахуйн нэгжээс гаргасан өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна.	17
3 дугаар бүлэг: Тайлант онд хэрэгжүүлж дуусгахаар гэрээ байгуулсан нийт төсөл, арга хэмжээний 90.2 хувь нь төлөвлөсөн үр дүндээ хүрсэн байна.	17
3.1 Тайлант онд хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан 8,688.7 сая төгрөгийн гэрээний дүнтэй 16 төсөл, арга хэмжээ нь хэрэгжээгүй байна.	18
3.2 Аймаг, сумдын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнүүдийн үе шат бүрд захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлж, комиссын актаар хүлээн авсан байна.	21
3.3 Тайлант онд ашиглалтад хүлээн авсан нийт 631.5 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 8 төсөл, арга хэмжээг бүртгэл, тайланд тусгаагүй байна.	23
Илрүүлсэн зөрчил	25
Дүгнэлт	26
Зөвлөмж	27

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын Их Хурал
ХААГ	Худалдан авах ажиллагааны газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Хүснэгтийн товьёг

Д/д	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Аймаг, сумдын ОНХО-аар 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний жагсаалт	6
Хүснэгт 2	2025 онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээ нь хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байдал	7
Хүснэгт 3	Зураг, төсвийг орон нутгийн төсөв батлагдсаны дараа батлагдсан төсөвт өртөгт нь багтаан гүйцэтгэсэн төсөл, арга хэмжээний жагсаалт	11
Хүснэгт 4	Хэрэгжээгүй төсөл, арга хэмжээний жагсаалт	15
Хүснэгт 5	Гомдлын шийдвэрлэлт	17
Хүснэгт 6	Тайлант онд гүйцэтгэлийн баталгаагаар баталгаажуулаагүй төсөл, арга хэмжээний жагсаалт	20
Хүснэгт 7	Тайлант онд бүрэн хэрэгжиж, комиссын актаар ашиглалтад хүлээж авсан боловч бүртгэлд тусгаагүй төсөл, арга хэмжээний жагсаалт	24

Дүрслэлийн товьёг

Д/д	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Худалдан авах ажиллагааны төлөвлөлт	14
Дүрслэл 2	Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	14
Дүрслэл 3	Төсөл, арга хэмжээний хэрэгжилт	19

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ	
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2025 оны “Аудитын сэдэв батлах тухай” 25 дугаар тогтоолыг үндэслэн Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.
Аудитын зорилт:	Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулахад аудитын зорилт оршлоо. Уг зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд: <ul style="list-style-type: none"> • <i>Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг оновчтой төлөвлөсөн үү?</i> • <i>Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулж, хяналт хэрэгжүүлсэн үү?</i> • <i>Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж төлөвлөсөн үр дүнд хүрсэн үү?</i>
Аудитын хамарсан хүрээ:	Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, худалдан авах ажиллагаа, санхүүжилт, захиалагчийн хяналтыг зохион байгуулсан аймгийн ТЕЗ, ХААГ, ОНӨГ, аймаг, сумдын ЗДТГ, “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ зэрэг холбогдох байгууллага болон төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, худалдан авах ажиллагаа, санхүүжилтийн баримт материалуудыг хамруулан аудитыг хийж гүйцэтгэлээ.
Аудитын арга зүй:	Аудитыг АДБОУС 3000-3100, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу гүйцэтгэлээ. Аудитад аймаг, сумдын Засаг дарга, ЗДТГ, аймгийн Худалдан авах ажиллагааны газар, “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ-ын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, баримт, материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглаж, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулан аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын шалгуур, үзүүлэлт:	Аудитад дараах шалгуур үзүүлэлтүүдийг ашиглалаа. Үүнд: <ul style="list-style-type: none"> • <i>Төсвийн тухай хууль,</i> • <i>Төрийн хэмнэлтийн тухай хууль,</i> • <i>Төсвийн тогтвортой байдлын тухай хууль,</i> • <i>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,</i>

	<ul style="list-style-type: none"> • Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, • Барилгын тухай хууль, • Эрчим хүчний тухай хууль, • Авто замын тухай хууль, • Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, • Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”, • Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар”, • Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам болон холбогдох аргачлалууд”, • Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”, • Сангийн сайдын 2023 оны А/261, 2025 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Харьцуулалтын аргаар үйлчилгээ авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг”, • Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Сэлэнгэ аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”, • Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 2025 оны 22 дугаар тогтоолоор баталсан “Сэлэнгэ аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөө”, • Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт, • Барилга байгууламжийн үнэ бүрдэл, төсөв зохиох норм, дүрэм, стандарт, • Батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, ажил гүйцэтгэх гэрээ болон холбогдох бусад эрх зүйн актууд.
<p>Аудитын бүрэлдэхүүн, хугацаа:</p>	<p>Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Батмөнх удирдаж, ахлах аудитор Ц.Отгонбаяр явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, ахлах аудитор С.Баасансүрэн, аудитор Ж.Баясгалан, Р.Отгонжаргал нар 2026 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 5 дугаар сарын 11-ний өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.</p>
<p>Ерөнхий мэдээлэл:</p>	<p>Аймаг болон сумдын орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд өмнөх оноос дамжин хэрэгжих 9,693.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 62, шинээр хэрэгжих 14,529.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 133 зэрэг нийт 24,223.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 195 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, аймаг, сумдын ИТХ-аар эцэслэн баталсан байна.</p> <p>Аймаг, сумдын өмнөх оноос шилжин хэрэгжих 825.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 7 /өмнөх онд худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй/, шинээр хэрэгжих 14,487.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 132 зэрэг нийт 15,312.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 139 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг Засгийн газрын 2024 онд баталсан 02 дугаар “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар” тогтоолыг баримтлан зохион байгуулахаар төлөвлөсөн байна.</p>

Аймаг, сумдын хөрөнгө оруулалтаар нийт 22,935.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 193 төсөл, арга хэмжээг 2025 онд хэрэгжүүлж дуусахаар төлөвлөснөөс 164 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг амжилттай зохион байгуулан, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан боловч худалдан авах ажиллагаанд гүйцэтгэгч шалгараагүй үндэслэлээр Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.2 дахь заалтуудын дагуу төсвийн хэмнэлтэд тооцон тайлант онд хэрэгжих 2,460.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 29 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй байна.

Бүлэг 1

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг оновчтой төлөвлөсөн үү?

Захиалагч нь ажлын зураг, төсөв боловсруулах даалгаврыг батлаагүйгээс техникийн шаардлага тодорхой бус болох, зураг төсөвт өөрчлөлт орох, төсөвт өртөг нэмэгдэх, чанар, үр ашиг буурах зэрэг эрсдэлийг дагуулж байна

1.1 Хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан, нэн тэргүүнд хэрэгцээ шаардлагатай төсөл, арга хэмжээг төлөвлөсөн үү?

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 91.0 хувийг аймаг, сумдын хөгжлийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан төлөвлөсөн байна

1.1.1 Сэлэнгэ аймаг болон сумдын орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд өмнөх оноос дамжин хэрэгжих 9,693.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 62, шинээр хэрэгжих 14,529.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 133 зэрэг нийт 24,223.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 195 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, аймаг, сумдын ИТХ-аар эцэслэн баталсан байна. (Дэлгэрэнгүйг Хавсралт 1-д харуулав) Үүнийг дараах хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 1 Аймаг, сумдын ОНХО-аар 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний жагсаалт

/сая төгрөг/

№	Аймаг, сумын нэр	Төсөл, арга хэмжээ				Нийт	
		Шилжин хэрэгжих	Төсөвт өртөг	Шинээр хэрэгжих	Төсөвт өртөг	Төсөл, арга хэмжээний тоо	Төсөвт өртөг
1	Аймаг	34	1,907.2	49	7,099.2	83	9,006.4
2	Баянгол	-	-	4	144.0	4	144.0
3	Ерөө	8	2,404.2	10	1,908.8	18	4,313.0
4	Мандал	7	770.7	19	1,204.6	26	1,975.3
5	Орхон	-	-	8	261.5	8	261.5
6	Сайхан	2	280.0	-	-	2	280.0
7	Сүхбаатар	5	665.2	31	3,192.0	36	3,857.2
8	Түшиг	2	65.0	6	379.4	8	444.4
9	Хүдэр	3	3,596.4	1	7.3	4	3,603.7
10	Цагааннуур	1	5.2	-	-	1	5.2
11	Шаамар	-	-	5	332.3	5	332.3
Нийт дүн		62	9,693.9	133	14,529.1	195	24,223.0

Эх сурвалж: Аймаг, сумдын ИТХ-ын 2025 оны тогтоолууд

1.1.2 Тухайн онд төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хөгжлийн жилийн төлөвлөгөө зэрэг богино болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй нийцсэн,

Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

тэдгээрийн хэрэгжилтийг хангах зорилттой уялдуулан төлөвлөсөн байхаар зохицуулсан байдаг.

1.1.3 Аймаг, сумдын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр “Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн зорилт, арга хэмжээтэй уялдаагүй 12, аймаг, сумын Засаг даргын 2025 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт, арга хэмжээтэй уялдаагүй 12 төсөл, арга хэмжээ (*давхардсан тоогоор*) -г төлөвлөж, аймаг, сумдын ИТХ-аар баталсан байна. Үүнийг дараах хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 2 2025 онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээ нь хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байдал

/сая төгрөг/

№	Аймаг, сумын нэр	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөл, арга хэмжээний ангилал	Шинэ, шилжих	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг	Бодлогын баримт бичигтэй уялдсан эсэх	
					Эхлэх	Дуусах		2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	Засаг даргын тухайн жилийн үйл ажиллагааны хөтөлбөр
1	Аймаг	Аймгийн улсын хяналтын байцаагч нарт автомашин худалдан авах	Тоног төхөөрөмж	Шинэ	2025	2025	150.0	Үгүй	Үгүй
2	Аймаг	Тоног төхөөрөмж худалдан авах /Аймгийн ИТХ/	Тоног төхөөрөмж	Шинэ	2025	2025	170.0	Үгүй	Үгүй
3	Аймаг	Лед дэлгэц /Аймгийн татварын газар/	Тоног төхөөрөмж	Шинэ	2025	2025	20.0	Үгүй	Үгүй
4	Аймаг	Автомашин /Гадаадын иргэн харьяатын газрын хойд бүс дэх газар/	Тоног төхөөрөмж	Шинэ	2025	2025	138.0	Үгүй	Үгүй
5	Аймаг	Захирагчийн албан зөврийн компьютер /Шаамар сум, Дулаанхаан тосгон/	Тоног төхөөрөмж	Шинэ	2025	2025	4.3	Үгүй	Үгүй
6	Аймаг	Дээврийн засвар /Аймгийн байгаль орчны газар/	Их засвар, тохижилт	Шинэ	2025	2025	148.2	Үгүй	Үгүй
7	Аймаг	Аймгийн нэгдсэн музейн барилгын дээврийн засвар	Их засвар, тохижилт	Шинэ	2025	2025	127.2	Үгүй	Үгүй
8	Аймаг	Шүүхийн тамгын газрын барилгын өргөтгөлийн засвар	Их засвар, тохижилт	Шинэ	2025	2025	45.0	Үгүй	Үгүй
9	Аймаг	Үндэсний шагайн Баянхан холбооны танхимын засвар	Их засвар, тохижилт	Шинэ	2025	2025	17.4	Үгүй	Үгүй
10	Аймаг	Аймгийн нэгдсэн музейн барилгын дотор засвар	Их засвар, тохижилт	Шинэ	2025	2025	101.4	Үгүй	Үгүй
11	Ерөө сум	ЗДТГ-ын өрөөний засвар	Их засвар, тохижилт	Шинэ	2025	2025	20.0	Үгүй	Үгүй
12	Сүхбаатар сум	Нуурын Экосистемийн судалгаа, дүгнэлт, нөхөн сэргээх зураглал /Боргүвээ 5 дугаар баг/	Зураг төсөв, зөвлөх үйлчилгээ, бусад	Шинэ	2025	2025	50.0	Үгүй	Үгүй
Нийт дүн							991.5		

Эх сурвалж: Аймаг, сумдын ИТХ-ын 2025 оны тогтоолууд

1.1.4 Дээрхээс бусад тайлант онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг аймаг, орон нутгийн хөгжлийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдуулж төлөвлөсөн байна. Өөрөөр хэлбэл хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 91.0 хувийг аймаг, сумдын хөгжлийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан төлөвлөсөн байна.

1.1.5 Баянгол, Ерөө, Орхон, Сүхбаатар зэрэг 4 сум нь нийт 5,506.3 сая төгрөгийн өртөг бүхий 53 төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, нэн тэргүүний хэрэгцээ шаардлагыг нь үнэлж, эрэмбэлэлгүйгээр тайлант онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөж, сумын ИТХ-аар батлуулсан байна. Үүнийг тодруулбал:

Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

- Баянгол сум нь нийт 144.0 сая төгрөгийн өртөг бүхий 4 төсөл, арга хэмжээ,
- Ерөө сум нь нийт 1,908.8 сая төгрөгийн өртөг бүхий 10 төсөл, арга хэмжээ,
- Орхон сум нь нийт 261.5 сая төгрөгийн өртөг бүхий 8 төсөл, арга хэмжээ,
- Сүхбаатар сум нь 3,192.0 сая төгрөгийн өртөг бүхий 31 төсөл, арга хэмжээ зэрэг.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29¹.1, Сангийн сайдын 2023 оны 278 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.1¹ дэх заалтуудтай нийцэхгүй байна.

1.1.6 Дээрх 4 сум нь төсөл, арга хэмжээг эрэмбэлээгүйгээс хөрөнгө оруулалтын шинж чанартай бус жижиглэсэн буюу байгууллагын урсгал зардалд тусган хэрэгжүүлэх боломжтой нийт 212.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий дараах 12 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна. Үүнд:

- Баянгол сум 19.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Төрийн үйлчилгээний пос машин худалдаж авах”, 20.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Цагдаа хэсгийн байрны дотоод засвар”,
- Ерөө сум 20.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “ЗДТГ-ын өрөөний засвар”, 8.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Ахмадын өргөөний халаалтын шугамын засвар”,
- Орхон сум тус бүр нь 20.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Эко нойл худалдаж авах”, “Эмчийн байрны засварын материал худалдан авах”,
- Сүхбаатар сум тус бүр нь 15.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Өрхийн эмнэлгийн хашаа шинэчлэх (Хонгорморьт 1-р баг)”, “Сүхбаатар сумын 1 дүгээр цэцэрлэгийн агааржуулалтын систем хийх”, “Ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн гадна фасад засвар хийх (Бор гүвээ 5-р баг)”, тус бүр нь 20.0 сая төгрөгийн “Сүхбаатар сумын төв талбайн сүлд мод худалдан авах”, “Партизаны талбайн гэрэлтүүлгийн ажил”, “4-р сургуулийн кабинетын тохижилт” гэх мэт.

1.1.7 Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцож, нэн тэргүүний хэрэгцээ шаардлагыг эрэмбэлж, төлөвлөхгүй байгаа нь хөрөнгө оруулалтын үр ашиг, үр нөлөөг бууруулж, мөн чанарыг алдагдуулж байна гэж үзэж байна. Тухайлбал:



Сүхбаатар сум нь орон нутгийн төсвийн хөрөнгөөр нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашиг, нэн тэргүүний хэрэгцээ шаардлагыг үнэлж, эрэмбэлээгүйгээс “Онцгой төгөл талбайн тохижилт (Бор гүвээ 5-р баг)” төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр 78.0 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

¹ Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ нь Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцсэн, холбогдох аргачлалд заасны дагуу шалгуур үзүүлэлтээр үнэлэгдсэн, эдийн засгийн үр ашигтай, нийгмийн ач холбогдолтой тэргүүлэх зэрэглэлийн төслүүд байна.

Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

1.1.8 Тайлант онд аймгийн ОНХО-аар шинээр барилга байгууламж барих төсөл, арга хэмжээг төлөвлөгөөгүй тул хөрөнгийн ашиглалттай холбоотой зардлын тооцоог урьдчилан хийгээгүй байна.

1.1.9 Харин Сүхбаатар сум нь тайлант онд шинээр хэрэгжүүлэх 500.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Хүнсний агуулахын барилга барих” төсөл, арга хэмжээний ашиглалтын зардлыг урьдчилан тооцоогүй байна. Энэ нь Төвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29¹.2 дахь “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байх”, 29¹.2.4 дэх “урсгал зардал гарах төслийн урсгал зардлыг тооцсон байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.1.10 Аймаг, сумын ОНХО-аар улсын төсвийн байгууллагуудын өмчлөл болон нийтийн эзэмшилд шилжих 13 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр нийт 1,171.7 сая төгрөг (аймгийн ОНХО-аар 12 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр нийт 1,162.8 сая төгрөг, Мандал сумын ОНХО-аар 1 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр 8.9 сая төгрөг) -ийг шат шатны ИТХ-аар батлуулсан байна. (Дэлгэрэнгүйг Хавсралт 2-т харуулав)

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24 дэх “хөрөнгө оруулалт гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг” гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2 Төсөвлөлтийн шаардлага үр дүнг оновчтой тодорхойлсон төсөл, арга хэмжээг төлөвлөсөн үү?

Шатны шатны захиалагч нь ОНХО-ын төсөл, арга хэмжээний зураг, төсөв боловсруулах ажлын даалгаврыг боловсруулж, батлаагүй байна.

1.2.1 Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4²-т хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгахаар зохицуулагдсан байдаг.

1.2.2 Тайлант онд аймаг болон дараах 5 суманд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зураг, төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний, их засварын нийт 7,057.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 43 төсөл, арга хэмжээний зураг, төсөв боловсруулах ажлын даалгаврыг боловсруулж, батлаагүй байна. Үүнд:

- Аймаг нь нийт 5,058.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 25 төсөл, арга хэмжээ,
- Баянгол сум нь нийт 104.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 2 төсөл, арга хэмжээ,
- Мандал сум нь 40.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 төсөл, арга хэмжээ,
- Сүхбаатар сум нь нийт 1,300.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 9 төсөл, арга хэмжээ,
- Түшиг сум нь нийт 339.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 4 төсөл, арга хэмжээ,

² Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

- *Шаамар сум нь нийт 215.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 2 төсөл, арга хэмжээ зэрэг.*

Энэ нь Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн 3 дугаар зүйлийн 3.4³, 3.5⁴ дахь заалтыг зөрчсөн байна.

1.2.3 Захиалагч нь ажлын зураг, төсөв боловсруулах даалгаврыг батлаагүйгээс техникийн шаардлага тодорхой бус болох, зураг төсөвт өөрчлөлт орох, төсөвт өртөг нэмэгдэх, чанар, үр ашиг буурах эрсдэлийг дагуулж байна

1.2.4 Ерөө сум нь захиалагч сумын Засаг даргын баталсан бус Бугант тосгоны захирагчийн баталсан техникийн тодорхойлолтыг үндэслэн “Онцгой байдлын гал унтраах ангийн газар худалдан авах” төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр 35.0 сая төгрөгийг төлөвлөсөн байна. Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.5 дахь “Аймаг, сум, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээний хувьд **тухай шатны Засаг дарга захиалагч байна**” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2.5 Тайлант онд сумдын ОНХО-аар шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 84 төсөл, арга хэмжээний зураг төсөв, техникийн тодорхойлолтыг урьдчилан боловсруулсан бол аймгийн ОНХО-аар шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 49 төсөл, арга хэмжээнээс зураг төсөв, техникийн тодорхойлолт нь урьдчилан хийгдээгүй 2 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр төсөвлөсөн байна. Үүнд:



Зураг, төсөв нь хийгдээгүй “Автомашинны гражийн барилгын өргөтгөл (Аймгийн онцгой байдлын газар)” төсөл, арга хэмжээ,



Техникийн тодорхойлолтыг боловсруулаагүй “Ерөнхий боловсролын 1-р сургууль, Хэрхийн сургуулийн спорт заалны гадна инженерийн шугам худалдан авах (Мандал сум)” төсөл, арга хэмжээ зэрэг.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, **зураг төсвөө батлуулсан**, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2.6 Сүхбаатар сум нь шинээр хэрэгжих “Нуурын Экосистемийн судалгаа, дүгнэлт, нөхөн сэргээх зураглал (Бор гүвээ 5 дугаар баг)” төсөл, арга хэмжээг мэргэжлийн байгууллага буюу ШУА-ийн Газарзүй, геоэкологийн хүрээлэнгээр хийлгэсэн хэдий ч 50.0 сая төгрөгийн төсөвт өртгийг хэрхэн тооцож, төлөвлөсөн нь тодорхой бус байна.

1.2.7 Аймаг, сумын ОНХО-аар шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт 133 төсөл, арга хэмжээнээс зураг, төсвийг урьдчилан хийлгээгүй орон нутгийн төсөв батлагдсаны дараа батлагдсан төсөвт өртөгт нь багтаан гүйцэтгэсэн 8 төсөл, арга хэмжээ (их засварын 5, дэд бүтэц 3) -г хэрэгжүүлэхээр нийт **1,143.0** сая төгрөгийг төлөвлөсөн байна. Үүнийг дараах хүснэгтээр харуулбал:

³ Архитектур төлөвлөлтийн даалгаврыг аймаг, нийслэлийн ерөнхий архитектур батална.

⁴ Захиалагч барилга байгууламжийн байршлыг тогтоосон шийдвэр, батлагдсан архитектур төлөвлөлтийн даалгаврыг үндэслэж зураг төслийн даалгавар боловсруулж батална.

Хүснэгт № 3 Зураг, төсвийг орон нутгийн төсөв батлагдсаны дараа батлагдсан төсөвт өртөгт нь багтаан гүйцэтгэсэн төсөл, арга хэмжээний жагсаалт

/сая төгрөг/

№	Аймаг, сумын нэр	Төсөл, арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг	Зураг, төсөв хийлгэх гэрээний	
			Эхлэх	Дуусах		Эхлэх	Дуусах
1	Аймаг	Цэцэрлэгийн засвар /Зүүнбүрэн сум/	2025	2025	320.0	2025.02.01	2025.02.15
2	Аймаг	Эрүүл мэндийн төвийн барилгын гадна фасад, дотор халаалтын засвар /Сайхан сум, Номгон тосгон/	2025	2025	187.9	2025.01.13	2025.01.17
3	Аймаг	Захирагчийн албаны барилгын дотор сантехникийн засвар /Сайхан сум, Номгон тосгон/	2025	2025	95.2	2025.01.13	2025.01.17
4	Аймаг	Аймгийн нэгдсэн музейн барилгын дээврийн засвар	2025	2025	127.2	2025.02.10	2025.02.14
5	Аймаг	Аймгийн нэгдсэн музейн барилгын дотор засвар	2025	2025	101.4	2025.02.10	2025.02.14
Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын дүн					831.7		
1	Мандал сум	Найрамдал, Ширхэнцэгийн гудамжны урд хэсгийн тогны хүчдэлийг тэнцвэржүүлэх	2025	2025	65.0	2025.05.01	2025.06.15
2	Мандал сум	1-р багийн стадионы баруун талын задгай хэсгийн шинэ суурьшлын бүсийн цахилгаан хангамж	2025	2025	89.3	2025.05.01	2025.06.01
3	Мандал сум	3-р баг Баянбулаг гудамжны шинэ суурьшлын бүсийн цахилгаан хангамж	2025	2025	157.0	2025.05.01	2025.06.01
Мандал сумын төсвийн хөрөнгө оруулалтын дүн					311.3		
Нийт дүн					1,143.0		

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2.7 Тайлант онд аймгийн ОНХО-аар барилга байгууламж шинээр барих бус их засвар, тохижилтын 21, тоног төхөөрөмж худалдан авах 21, авто зам, дэд бүтэц 1, зураг төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээ 6 зэрэг нийт 49 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн тул магадлал хийлгэж баталгаажуулах шаардлагагүй гэж үзсэн болно.

1.2.8 Харин Сүхбаатар сум нь тайлант онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн “Хүнсний агуулахын барилга барих” төсөл, арга хэмжээ (500.0 сая төгрөгийн төсөвт өртгийн давхцалыг хасаж тооцсон) -ний зураг, төсөвт магадлал хийлгэж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29¹.2 дахь “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байх”, 29¹.2.2 дахь “ барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн

Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2.9 Тайлант онд шинээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг аймаг болон Мандал, Сүхбаатар сум нь хэрэгжих хугацаанд нь тэнцүү хуваарилаагүй, 2025 оны санхүүжилтийг дутуу буюу санхүүжих дүнгүйгээр төлөвлөж, ИТХ-аар баталсан байна. Үүнийг тодруулбал:

- *Аймгийн ОНХО-аар 2025-2026 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 2 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг хэрэгжих хугацаанд нь тэнцүү хуваарилаагүйгээс тайлант оны санхүүжих дүнг нийт 633.9 сая төгрөг (767.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Аймгийн Биеийн тамир, спортын газрын барилгын фасадын засвар” төсөл, арга хэмжээний тайлант онд санхүүжих дүнг 270.0 сая төгрөг буюу 113.9 сая төгрөгөөр дутуу, 520.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Сүхбаатар сумын 3-р багийн инженерийн шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэл” төсөл, арга хэмжээг тайлант онд санхүүжих дүнгүйгээр төлөвлөсөн) -өөр дутуу төлөвлөсөн,*
- *Мандал, Сүхбаатар сум нь 2025 онд шинээр эхлэн хэрэгжүүлж дуусахаар төлөвлөсөн 11 төсөл, арга хэмжээний тайлант оны санхүүжилтийг нийт 1,129.0 сая төгрөгөөр дутуу буюу санхүүжих дүнгүйгээр төлөвлөсөн байна.*

1.2.10 Харин 2022-2025 онд буюу өмнөх онуудаас шилжин хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг аймаг болон 7 сум нь хэрэгжих хугацаанд нь тэнцүү хуваарилаагүйгээс тайлант оны санхүүжих дүнг дараах байдлаар илүү, дутуу төлөвлөж, ИТХ-аар баталсан байна. Үүнд: *(Дэлгэрэнгүйг Хавсралт 3, 4-т харуулав)*

- *Аймгийн ОНХО-аар 2023-2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 34 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг хэрэгжих хугацаанд нь тэнцүү хуваарилаагүйгээс тухайн онд санхүүжих дүнг 26 төсөл, арга хэмжээг 1.5-73.7 сая төгрөгөөр илүү, 8 төсөл, арга хэмжээг 3.5-33.9 сая төгрөгөөр дутуу санхүүжүүлэхээр төлөвлөсөн,*
- *Ерөө сум 8, Мандал сум 7, Сайхан сум 2, Сүхбаатар сум 5, Түшиг сум 2, Хүдэр сум 3, Цагааннуур сум 1 зэрэг нийт 28 төсөл, арга хэмжээг 2022-2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд санхүүжилтийг хэрэгжих хугацаанд тэнцүү хуваарилаагүйгээс тухайн онд санхүүжих дүнг 17 төсөл, арга хэмжээг 2.6-135.0 сая төгрөгөөр илүү, 10 төсөл, арга хэмжээг 6.3-1,334.7 сая төгрөгөөр дутуу санхүүжүүлэхээр төлөвлөсөн бол 1 төсөл, арга хэмжээг төсөвт өртөг, тухайн онд санхүүжих дүнгүйгээр төлөвлөсөн.*

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3⁵ дахь заалтыг зөрчсөн байна.

1.2.11 Санхүүжилтийг хэрэгжих хугацаанд нь тэнцүү хуваарилахгүй, тухайн онд санхүүжих дүнгүйгээр баталж байгаагаас сонгон шалгаруулалт амжилтгүй болох, улмаар төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаандаа бүрэн хэрэгжихгүй байх эрсдэлийг дагуулж байна.

⁵ ... төсөл, арга хэмжээний нийт саналыг дараах байдлаар жилийн төсвийн төсөлд тусгана: 29.3.5. шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож, гурван жилд багтаан санхүүжүүлж дуусгах.

Бүлэг 2

Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулж, хяналт тавьсан уу?

Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулсан байна.

2.1 Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу, хугацаанд нь зохион байгуулсан уу?

Зураг төсөв, техникийн тодорхойлолтыг боловсруулаагүйгээс шалтгаалан 4 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй байна.

2.1.1 ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 44 дүгээр 44.1⁶-д заасны дагуу “2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө”-г Сэлэнгэ аймгийн Засаг дарга нь 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдөр, сумдын Засаг дарга нар 2025 оны 01 дүгээр сарын 02-ноос 10-ны өдрийн хооронд баталж, цахим системд нийтэлсэн байна.

2.1.2 Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжүүлэх эрхийг Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.1.1⁷-т заасны дагуу холбогдох албан тушаалтанд шилжүүлэхээр зохицуулагдсан байдаг.

2.1.3 Аймгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан 304.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл, арга хэмжээний хэрэгжүүлэх эрхийг аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн А/29 дүгээр захирамжаар Баянгол, Түшиг, Орхон сумдад шилжүүлсэн бөгөөд журамд заасан хугацаанаас 9 хоногоор хэтрүүлсэн байна.

2.1.4 ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 50 дүгээр 50.1⁸-д заасны дагуу аймаг, сумдын ОНХО-аар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах “Үнэлгээний хороо”-г 3-7 хүний бүрэлдэхүүнтэйгээр, аймгийн ХААГ-ын даргын тушаалаар, сумдын хувьд сумын Засаг даргын захирамжаар тус тус байгуулсан байна.

⁶ Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална

⁷ Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн хөрөнгө оруулалтын арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан тухайн жилийн 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор багтаан дараах эрхээ доор дурдсаны дагуу шилжүүлж болох бөгөөд энэ талаар гаргасан шийдвэрээ ажлын 5 хоногт багтаан цахим системд оруулж, баталгаажуулна.

⁸ Захиалагч энэ хуулийн 10.2-т зааснаар бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаас бусад тохиолдолд үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулна:

50.1.1.100 сая төгрөг хүртэл төсөвт өртөгтэй тендер шалгаруулалтын үнэлгээний хороог гурваас доошгүй;

50.1.2.ерөнхий гэрээний нэгдүгээр үе шатны, эсхүл энэ хуулийн 50.1.1-д зааснаас бусад тендер шалгаруулалтын үнэлгээний хороог таваас доошгүй.



2.1.6 Тайлант онд 14,982.8 сая төгрөгийн өртөгтэй 135 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг дараах аргуудаар зохион байгуулсан байна /Дэлгэрэнгүйг Судалгааг 2-т харуулав./

2.1.5 Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртөгийн дээд хязгаар” баталсан 02 дугаар тогтоолыг баримтлан 2025 онд аймаг, сумд нийт 15,312.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 139 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөсөн байна.



2.1.7 Шат шатны захиалагч нь аймаг, сумдын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан 330.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 4 төсөл, арга хэмжээний зураг төсөв, техникийн тодорхойлолт боловсруулж, батлуулаагүйгээс тайлант онд худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй байна. Үүнд:

Аймгийн хөрөнгө оруулалт:

- Автомашины гражийн барилгын өргөтгөл /Аймгийн ОБГ/-170.0 сая төгрөг,
- Ерөнхий боловсролын 1-р сургууль, Хэрхийн сургуулийн спорт залны гадна инженерийн шугам худалдан авах /Мандал сум/-100.0 сая төгрөг,

Сумын хөрөнгө оруулалт:

- Мандал сум “Зүүнхараа Политехник Коллежийн спорт заалны зураг төсвийн зардал”- 40.0 сая төгрөг,
- Сүхбаатар сум “Хүүхэд залуучуудын талбайн ажлын зураг төсвийн зардал”- 20.0 сая төгрөгийн төсөв өртөгтэй төсөл арга хэмжээ.

2.1.8 Төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг оройтож зарласан, оролцогч санал ирүүлээгүй болон шаардлага хангасан оролцогч шалгараагүй зэргээс шалтгаалан нийт 2,396.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 19 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа амжилтгүй болж, гүйцэтгэгч шалгараагүй тул Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1⁹, 13.1.2¹⁰-д заасны дагуу хэмнэлтэд тооцсон байна.

Хүснэгт №4. Хэрэгжээгүй төсөл, арга хэмжээний жагсаалт

⁹ Батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах;
¹⁰ Энэ хуулийн 13.1.1-д заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй бол төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох;

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг
Аймгийн хөрөнгө оруулалтаар		
1	Инженерийн шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэл /Сүхбаатар сум, 3-р баг/	520.0
2	Цагдаагийн хэсгийн түр хяналтын цэгийн тоног төхөөрөмж /Ерөө сум, Бугант тосгон/	9.3
3	Эрүүл мэндийн төвийн ажилчдын байрны засвар /Орхон сум/	20.0
4	Цэвэрлэх байгууламжийн зураг төсөв /Орхон сум/	40.0
Мандал сумын хөрөнгө оруулалтаар		
1	Бохирын шугам барих зураг төсвийн зардал /3,7,9-р баг/	120.0
2	Киоск машин худалдан авах (газрын 18 төрлийн үйлчилгээ)	98.0
Орхон сумын хөрөнгө оруулалтаар		
1	Зураг төсвийн зардал	39.0
Сүхбаатар сумын хөрөнгө оруулалтаар		
1	Хүнсний агуулахын барилга барих	500.0
2	Цахилгаан үүсгүүр худалдан авах /ЕБ-ын 3-р сургууль/	40.0
3	Хогны бункер худалдан авах /ЕБ-н 2-р сургууль, Ганзам 7-р баг/	27.0
4	Орхон голын эргийн цэцэрлэгт хүрээлэнгийн зураг төсвийн зардал	50.0
5	Гэрэлт цогцолборыг шинэчлэх зураг төсвийн зардал	30.0
6	Сүхбаатар-90 цэцэрлэгт хүрээлэн спорт талбай зураг төсвийн зардал /8-р баг/	50.0
7	Олон нийтийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх зөөврийн 00 худалдан авах	60.0
8	Хуванцар хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмж худалдан авах	434.0
9	Дулааны шугам засвар, шинэчлэл /4, 6, 8-р баг/-	170.0
10	Гэрэлт гудамжны тохижилт хийх /Орхон 6-р баг ТЗ-н клубын урд гудамж/	120.0
11	Сайжруулсан зам, зогсоол хийх /7-р баг/	50.0
12	Замын тэмдэг тэмдэглэгээ, зам засвар	19.5
Нийт дүн		2,396.8

2.1.9 Шаамар сум нь 23.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Явган хүний замын зураг төсөв”-ийн худалдан авах ажиллагааг зохион байгуулалгүйгээр шууд гэрээ байгуулсан байна. Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2¹¹, 31 дүгээр зүйлийн 31.1¹², Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар” баталсан 02 дугаар тогтоолд заасныг тус тус зөрчсөн байна.

2.1.10 Аймгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан дараах 2 төсөл арга хэмжээний төсөвт өртгийг хуваан, харьцуулалтын аргаар тендер шалгаруулсан байна. Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3¹³-д заасныг зөрчсөн байна. Үүнд:

- Аймгийн нэгдсэн музейн барилгын дээвэр засвар-101.4 сая төгрөг,
- Аймгийн нэгдсэн музейн барилгын дотор засвар-127.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй зэрэг.

¹¹ Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно.;

¹² Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна:

¹³ Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно.

2.1.11 Ерөө сум нь 35.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Онцгой байдлын гал унтраах ангийн газар худалдан авах” төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог сумын Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/21 дүгээр захирамжаар 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

Уг үнэлгээний хороо тендерийн бичиг баримтыг боловсруулахдаа худалдан авах ажиллагаанд шаардлагатай нарийвчилсан шалгуур, нөхцөлийг тодорхой тусгаж, батлуулаагүй буюу тухайн газар нь 35.0 сая төгрөгийн үнэлгээтэй эсэх нь тодорхой бус, газрын өмчлөл, эзэмшлийн байдлыг нотлох зэрэг тухайн төсөл, арга хэмжээнд хамаарах үндсэн шалгуур үзүүлэлтийг тусгаагүй атал ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлага, тусгай зөвшөөрөл зэрэг газар худалдах үйл ажиллагааны онцлогт үл нийцэх шаардлага тавьсан байна.

Тухайн төсөл, арга хэмжээний тендерт ганц оролцогч буюу Баян-Өндөр булаг ХХК /Бугант гурван охин” ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч/-аас өөрийн эзэмшлийн бус Ерөө сумын Бугант тосгонд байрлалтай, 4301003018 нэгж талбарын дугаартай, үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газар зориулалттай 8100м² газрыг худалдах санал ирүүлснийг гүйцэтгэгчээр шалгаруулж, сумын Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 98 дугаар албан бичгээр “Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдээгдэл”-ийг хүргүүлсэн байна.

2.1.12 Тайлант онд холбогдох хууль, эрх зүйн зохицуулалтын дагуу дараах төсөл, арга хэмжээг тендер шалгаруулалтгүйгээр шууд гэрээ байгуулан хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- ТБОНӨХБАУХА тухай хуулийн 35.1.2¹⁴ дахь заалт болон аймгийн ОБГ-ын гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн 2024 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 31/01 дүгээр шийдвэрийн дагуу 80.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Сургуулийн дээврийн засвар /Түшиг сум” төсөл, арга хэмжээ,
- Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 31.5¹⁵ дахь заалтыг үндэслэн 50.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Нуурын Экосистемийн судалгаа, дүгнэлт, нөхөн сэргээх зураглал /Боргүвээ 5 дугаар баг” зөвлөх үйлчилгээ.

2.1.13 Нийт 14,982.9 сая төгрөгийн 135 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулснаас 114 гүйцэтгэгчид 12,165.2 сая төгрөгийн гэрээ байгуулах эрх олгон, нийт 559.3 сая төгрөгийн тендерийн хэмнэлт үүссэн байна.

2.1.14 Тайлант оны эцсээр аймаг нь төсөвт тодотгол хийж, шинээр 94.3 сая төгрөгийн 8 төсөл, арга хэмжээг шууд гэрээ байгуулахаар нэмэгдүүлэн баталсан нь төсөл, арга хэмжээг чанаргүй гүйцэтгэх, хугацаандаа ашиглалтад орохгүй байх, төсвийн үр ашиггүй зарцуулалт болох эрсдэлийг үүсгэж байна.

¹⁴ Онц байдал, гамшиг, ослын нөхцөл байдлын улмаас бий болсон хэрэгцээ, шаардлагыг даван туулахтай шууд холбогдох бараа, ажил, үйлчилгээг худалдан авах яаралтай хэрэгцээ бий болсон шалтгаанаар энэ хуульд заасан бусад аргаар тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй.

¹⁵ Засгийн газар, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь энэ хуулийн 3.1.11-т заасан судалгааны үндсэн чиглэлээр шинжлэх ухаан, технологийн төсөл, суурь судалгаа, хэрэглээний судалгаа, технологийн туршилт зүгшрүүлэлтийн ажлыг төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллагаар гүйцэтгүүлэх харилцаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль хамаарахгүй.

2.2 Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан эсэхийг хянаж, холбогдох арга хэмжээг авсан уу?

Тайлант онд тендер шалгаруулалттай холбоотой 6 аж ахуйн нэгжээс гаргасан өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна.

2.2.1 Тайлант онд зохион байгуулсан тендер шалгаруулалттай холбоотой захиалагчийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй үндэслэлээр 6 аж ахуйн нэгжээс өргөдөл, гомдол гаргасныг Сангийн яам хуулийн хугацаанд буюу 10 хоногийн дотор хянаж, дараах шийдвэрийг гаргасан байна. Тодруулбал:

- 1 тендер шалгаруулалтыг гомдол гаргасан аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэхээр,
- 1 тендер шалгаруулалтыг үнэлгээний хорооны шийдвэр хүчинтэйд тооцсон,
- 2 тендер шалгаруулалтыг худалдан авах ажиллагааг дахин үнэлэхийг тус тус шийдвэрлэсэн байна.

2.2.2 Сангийн яамнаас гомдол хянан шийдвэрлэсэн шийдвэрийг үндэслэн аймаг, сумд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Тодруулбал:

Хүснэгт №5. Гомдлын шийдвэрлэлт

/сая төгрөгөөр/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Гомдол гаргасан байгууллагын нэр	Шийдвэрлэсэн байдал	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
Аймгийн хөрөнгө оруулалтаар					
1	Цэцэрлэгийн барилгын цонх, хаалга, фасадын засвар /Сүхбаатар сум 2-р баг/	385.0	"Сэлэнгэ-Ундрам" ХХК	Гомдол үндэслэлгүй	Тендер шалгаруулалтыг үргэлжлүүлж, "Ривал констракшн" ХХК-тай гэрээ байгуулсан
2	24,27-р байрны засвар /Сүхбаатар/	244.5	СДММ ХХК	Гомдол үндэслэлтэй	Үнэлгээний хороо дахин хуралдаж, хамгийн бага үнийн санал ирүүлсэн СДММ ХХК-ийг шалгаруулан, гэрээ байгуулсан
			"Нар сар газар" ХХК	Захиалагчийн шийдвэр хүчинтэйд тооцсон	СДММ ХХК-тай гэрээ байгуулсан
Мандал сумын хөрөнгө оруулалтаар					
3	Мандал сумын үерийн хамгаалалтын барилга байгууламжийн иж бүрэн ажлын зураг т өсөл, төсөв боловсруулах"	420.0	"Хайдродизайн прожект" ХХК	Гомдол үндэслэлтэй	Тендерийг дахин үнэлж, Хайдродизайн прожект" ХХК-ийг шалгаруулан, гэрээ байгуулсан,
			"Хос ерөөл инженеринг" ХХК		
Шаамар сумын хөрөнгө оруулалтаар					
4	Бохир соруулах машин худалдан авах	69.5	Альянстейд ХХК	Гомдол үндэслэлтэй	Тендерийг дахин үнэлж, хамгийн сайн үнэлэгдсэн "Монтир транс" ХХК-ийг шалгаруулан, гэрээ байгуулсан.

Бүлэг 3

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж, төлөвлөсөн үр дүнд хүрсэн үү?

Тайлант онд хэрэгжүүлж дуусгахаар гэрээ байгуулсан нийт төсөл, арга хэмжээний 90.2 хувь нь төлөвлөсөн үр дүндээ хүрсэн байна.

3.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь санхүүжүүлж, гүйцэтгүүлсэн үү?

Тайлант онд хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан 8,688.7 сая төгрөгийн гэрээний дүнтэй 16 төсөл, арга хэмжээ нь хэрэгжээгүй байна.

3.1.1 Аймаг, сумдын хөрөнгө оруулалтаар нийт 22,935.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 193 төсөл, арга хэмжээг 2025 онд хэрэгжүүлж дуусахаар төлөвлөснөөс 164 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг амжилттай зохион байгуулан, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан боловч худалдан авах ажиллагаанд гүйцэтгэгч шалгараагүй үндэслэлээр Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.2 дахь заалтуудын дагуу төсвийн хэмнэлтэд тооцон тайлант онд хэрэгжих 2,460.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 29 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй байна. */Дэлгэрэнгүйг Судалгааг 3-т харуулав/*

3.1.2 Өмнөх оноос шилжин хэрэгжих 55, шинээр эхлэх 109 зэрэг нийт 164 төсөл, арга хэмжээ *(авто зам, дэд бүтцийн 16, барилга байгууламжийн 8, их засвар, тохижилтын 57, тоног төхөөрөмж 60, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ болон бусад 23)* -г тайлант онд хэрэгжүүлж дуусгахаар нийт 23,480.7 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна. *(Дэлгэрэнгүйг Судалгаа 3-т харуулав.)*



/Ерөө сумын Наадмын талбайн тохижилт/




/Сүхбаатар сумын Хүүхдийн тоглоомын талбай байгуулах/

3.1.3 Тайлант онд дуусгахаар гэрээ байгуулсан 164 төсөл, арга хэмжээнээс нийт 14,792.0 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 148 төсөл, арга хэмжээ нь бүрэн хэрэгжиж комиссын актаар ашиглалтад хүлээн авсан байна.

3.1.4 Тайлант жилд үүссэн төсвийн хүндрэл, сумдын төсвийн орлогын төлөвлөгөө тасарснаас санхүүжилт бүрэн олгогдоогүй, төсөл, арга хэмжээг гэрээт хугацаанд хүлээлгэж өгөөгүй зэргээс голлон шалтгаалж 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн аймгийн хөрөнгө оруулалтын 3, Ерөө сумын 4, Сүхбаатар сумын 2, Мандал, Түшиг, Хүдэр, Шаамар сумдын тус бүр 1 төсөл, арга хэмжээ зэрэг нийт 8,506.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй дутуу хэрэгжсэн 13 төсөл арга, хэмжээний гэрээний хугацааг 2026 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдөр хүртэлх хугацаанд сунгасан байна. */Дэлгэрэнгүйг Судалгааг 3-т харуулав/*

ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ



3.1.5 Гүйцэтгэгч нь гэрээний хугацаанд ажлаа гүйцэтгээгүй, техникийн шаардлага хангахгүй машин нийлүүлсэн тул комиссын дүгнэлтээр захиалагч гэрээгээ цуцалсан зэргээс шалтгаалан дараах 3 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй байна. Үүнд:

Аймгийн хөрөнгө оруулалт:

- “Юу Пи Ди планнер ХХК”-тай байгуулсан 27.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Мал нядалгааны үйлдвэр, борлуулалтын цэгийн зураг төсөв /Баянгол сум” төсөл, арга хэмжээ,
- “Юу Пи Ди планнер ХХК”-тай байгуулсан 20.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Ахуйн үйлчилгээний төвийн зураг төсөв /Баянгол сум” төсөл, арга хэмжээ,

Сумдын хөрөнгө оруулалт:

- “Менежмент ба ур чадварын хүрээлэн ХХК”-тай байгуулсан 135.6 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Ерөө, Бугантад хүүхэд зөөх 2 ширхэг автобус худалдаж авах” төсөл, арга хэмжээ,

3.1.6 ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 42.5¹⁶-д заасны дагуу тайлант онд комиссын актаар ашиглалтад оруулсан 148 төсөл, арга хэмжээнээс 44-д нь чанарын баталгааг гэрээний үнийн дүнгийн 5 хувиар тооцож, хөрөнгө оруулалтын барьцаа дансанд байршуулахаар гэрээнд тусгасны дагуу нийт 288.7 сая төгрөгийг байршуулсан байна.

3.1.7 Мөн Мандал сумын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн төсөл, арга хэмжээний санхүүжилттэй холбоотой нийт 103.8 сая төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- “Түнхэл тосгонд тоглоомын талбай байгуулах /Наадмын талбай/ 5-р баг” төсөл, арга хэмжээний санхүүжилт болох 35.5 сая төгрөгийг сумын ОНХС-ийн батлагдсан төсвөөс гүйцэтгэгч “Баян өргөн уул” ХХК-д шилжүүлсэн,
- 169.7 сая төгрөгийн гэрээний дүн бүхий “Хайрган хучилттай замын засвар 4.5.8.9-р баг” төсөл, арга хэмжээний 101.4 сая төгрөгийг ОНХО-ын төсвөөс

¹⁶ Бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгаа болон зүгшрүүлэх, тохируулах хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор захиалагч худалдан авах гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийг барьцаалах нөхцөлийг тендер шалгаруулалтын баримт бичигт тусгаж болно.

Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

санхүүжүүлэхээр сумын ИТХ-ын тогтоолд тусгагдсан боловч гэрээний санхүүжилтийг бүтнээр нь буюу 68.3 сая төгрөгийг ОНХО-ын батлагдсан төсвөөс илүү шилжүүлсэн,

3.1.8 ТБОНӨХБАУХА тухай хуулийн 42.1¹⁷-д заасны дагуу Үнэлгээний хороо нь 100.0 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй 37 төсөл, арга хэмжээнээс **33** төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч компаниудын өмнөөс ХААН, ХХБ, Голомт, Төрийн банкнууд нь гүйцэтгэлийн баталгаа гаргасан байна.

3.1.9 Харин захиалагчид нь нийт 549.3 сая төгрөгийн тайлант онд санхүүжих дүн бүхий **4** төсөл, арга хэмжээний 16.5 сая төгрөгийн гүйцэтгэлийн баталгааг банкны болон даатгалын байгууллагаар баталгаажуулалгүйгээр гэрээ байгуулсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №6. Тайлант онд гүйцэтгэлийн баталгаагаар баталгаажуулаагүй төсөл, арга хэмжээний жагсаалт

/сая төгрөгөөр/

№	Аймаг, сумын нэр	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөл, арга хэмжээний ангилал	Хугацаа		Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Гүйцэтгэгчийн нэр	Гүйцэтгэлийн баталгаа гаргавал зохих дүн
				Эхлэх	Дуусах				
1	Сэлэнгэ	Сумдад төрийн үйлчилгээний киоск машин	Тоног төхөөрөмж	2025	2025	110.0	108.6	Гэрэгэ киоск ХХК	3.3
2	Сүхбаатар	"Сэлэнгэ олон улс худалдааны төв"-ийн дээврийн засварын ажил	Их засвар, тохижилт	2025	2025	150.0	139.5	АВВКНСТ ХХК	4.2
3	Түшиг	Ахуйн үйлчилгээний байрны засвар	Их засвар, тохижилт	2025	2025	109.3	109.3	Халхаанбулаг ХХК	3.3
4	Шаамар	Гэрэлтүүлэг /Шаамар сум 1, 2-р баг/	Авто зам, дэд бүтэц	2025	2025	191.9	191.9	Нарсан цамхаг ХХК	5.8
Нийт дүн						561.2	549.3		16.5

3.1.10 Бүрэн хэрэгжсэн 148 төсөл, арга хэмжээнээс 141 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан *"Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"*-ын 4.8.28¹⁸, 4.8.29¹⁹-д заасны дагуу барилга байгууламж, тоног төхөөрөмж, их засварын ажлын хяналтын хуудас, гүйцэтгэлийн төсвийг үндэслэн захиалагч *"Гэрээ дүгнэх маяг"*-аар баталгаажуулсан байна. (Дэлгэрэнгүйг Судалгаа 3-т харуулав.)

3.1.11 Харин аймгийн хөрөнгө оруулалтаар тайлант онд бүрэн хэрэгжиж, комиссын актаар ашиглалтад хүлээж авсан нийт 84.7 сая төгрөгийн гэрээний дүнтэй дараах 7 төсөл, арга хэмжээг *"Гэрээ дүгнэх маяг"*-аар баталгаажуулаагүй байна. Үүнд:

¹⁷ Тендер шалгаруулалтын төсөвт өртөг 100.0 сая төгрөгөөс дээш бол гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа шаардана.

¹⁸ Захиалагч нь барилга байгууламж, их засварын ажил, тоног төхөөрөмж худалдан авах, зөвлөх үйлчилгээ болон худалдан авах төсөл зэрэг хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ тус бүрийн хяналтын хуудсыг энэ журмын хавсралтад заасан холбогдох маягтын дагуу бөглөж, баталгаажуулан ирүүлнэ.

¹⁹ Төсөл, арга хэмжээний эцсийн буюу бүрэн санхүүжилтийн хүсэлтэд гэрээг дүгнэсэн байх бөгөөд энэ журмын 16 дугаар хавсралтад заасан *"Гэрээ дүгнэх маяг"*-ыг үйлдэж баримт бичгийн иж бүрдэлд эх хувиар хавсаргаж ирүүлнэ.

- 19.9 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Эрүүл мэндийн төвд тоног төхөөрөмж /Түшиг сум”,
- 19.4 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Багш хөгжлийн төвд тоног төхөөрөмж авах /Түшиг сум”,
- 8.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Цэцэрлэгт хяналтын камер авах /Зүүнбүрэн сум”,
- 4.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Захирагчийн албан зөөврийн компьютер /Шаамар сум, Дулаанхаан тосгон”,
- 3.5 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Эрүүл мэндийн төвд программ хангамж /Шаамар сум”,
- 10.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Ерөнхий боловсролын сургуулийн үдийн цайны өрөөний өргөтгөлийн зураг төсөв /Шаамар сум, Дулаанхаан тосгон”,
- 19.9 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Гадаадын иргэн харьяатын газрын барилгын зураг төсөв” зэрэг.

3.1.12 Тайлант онд гэрээт ажлаа бүрэн хэрэгжүүлсэн дээрх 148 төсөл, арга хэмжээг “Комиссын акт”-аар хүлээлгэн өгсөн боловч Сангийн яамнаас 11,12 дугаар сард санхүүжилтийг түр зогсоосноос шалтгаалан 13 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчид олгох 508.1 сая төгрөгийн сая төгрөгийг санхүүжилтийг он дамжин олгосон байна.

3.1.13 Аймгийн ОНХО-ын төсөл, арга хэмжээний захиалагч нь өмнөх онд комиссын актаар хүлээж авсан, баталгаат хугацаанд чанарын гологдол гараагүй **26** төсөл, арга хэмжээний 206.6 сая төгрөгийн барьцааг чөлөөлж гүйцэтгэгч компаниудад шилжүүлсэн байна.

3.2 Барилга байгууламжийн үе шат бүрд захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлсэн үү?

Аймаг, сумдын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнүүдийн үе шат бүрд захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлж, комиссын актаар хүлээн авсан байна.

3.2.1 “Сэлэнгэ барилга захиалагч ОНӨААТҮГ” нь барилга байгууламж, их засварын өмнөх оноос шилжиж ирсэн 28, тайлант онд шинээр эхэлсэн 53 (тоног төхөөрөмж нийлүүлэх 61, зураг, төсөв, зөвлөх үйлчилгээний 23 зэрэг нийт 84 төсөл, арга хэмжээ хасагдсан) зэрэг нийт 81 төсөл, арга хэмжээнд Барилгын тухай хуулийн 37.1.4²⁰, Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга захиалагчийн дүрэм”-ийн 3.12²¹-т заасны дагуу захиалагчийн хяналтыг гүйцэтгэж, холбогдох баримтуудаар баталгаажуулан нийт 110.3 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

3.2.2 Тайлант онд гэрээт ажлаа бүрэн хэрэгжүүлж, “Комиссын акт”-аар хүлээлгэн өгсөн төсөл, арга хэмжээнүүдээс 40.6 сая төгрөгийн захиалагчийн хяналтын зардлыг Сангийн яамнаас 11,12 дугаар сард санхүүжилтийг түр зогсоосноос шалтгаалан 2026 онд олгосон байна.

²⁰ 37.1.Барилгын ажлын захиалагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 37.1.4.барилгын үе шатны ажилд хяналтыг хэрэгжүүлэхдээ энэ хуулийн 33.1.20-д заасан гэрээг байгуулж ажиллах.

²¹ Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр орон нутагт баригдах барилга байгууламжийн захиалагчийн хяналтыг тухайн аймаг, нийслэлийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан нэгжээр гэрээний үндсэн дээр төлөөлүүлэн гүйцэтгүүлж болно.

3.2.3 Тус газрын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий мэргэжилтнүүд нь Засгийн газрын 2019 оны 170 дугаар тогтоолоор баталсан “Барилга захиалагчийн дүрэм”-ийн 3.9²², Сангийн сайдын 2023 оны 287 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.4.1.3²³-т заасны дагуу төсөл, арга хэмжээний явц бүрд захиалагчийн техник, технологийн хяналтын тэмдэглэл, явцын тайлан, дүгнэлтээр баталгаажуулж, илэрсэн зөрчлийг арилгуулсан байна.

3.2.4 Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.5²⁴, Засгийн газрын 2019 оны 170 дугаар тогтоолоор баталсан “Барилга захиалагчийн дүрэм”-ийн 3.1.4²⁵, Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 178 дугаар тушаалаар баталсан “Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм”-ийн 3.2.3²⁶-т заасны дагуу төсөл, арга хэмжээний үе шат бүрд зураг, төсөв зохиогчийн техникийн хяналтыг гэрээний үндсэн дээр зураг, төсөв зохиогч компаниудаар гүйцэтгүүлж, илэрсэн зөрчлийг тухай бүр арилгуулсан байна.

3.2.5 Төсөл, арга хэмжээний эхний болон явцын санхүүжилтийг хяналт хэрэгжүүлсэн эрх бүхий албан тушаалтнуудын баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, ашиглагч байгууллагын тодорхойлолт, гүйцэтгэгчийн хүсэлтийг үндэслэн гэрээний тусгай нөхцөлд заасны дагуу 30.0-80.0 хувиар тооцож, гүйцэтгэгч компаниудад олгосон байна.

3.2.6 Тайлант онд өмнөх оноос шилжин хэрэгжих 55, шинээр эхлэх 110 (2025 онд 164, 2026 онд 1 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж дуусахаар гэрээ байгуулсан бол гүйцэтгээг шалгараагүйгээс 30 төсөл, арга хэмжээний гэрээ байгуулаагүй) зэрэг нийт 165 төсөл, арга хэмжээнд эхний болон явцын санхүүжилтийг олгосон байна.

3.2.7 Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.19²⁷-д заасны дагуу захиалагчийн болон зохиогчийн зүгээс барилгын ажлын үе шат бүрд хяналт тавьж, фото зураг болон ил, далд ажлын актаар баталгаажуулсан байна.

3.2.8 Тайлант онд бүрэн хэрэгжилгүйгээр он дамжсан 13 төсөл, арга хэмжээнээс барилга байгууламж, их засварын 5 төсөл, арга хэмжээний явцад захиалагч болон зохиогчийн хяналтыг хэрэгжүүлж, ажлын гүйцэтгэлийг тус бүрээр 40.0 - 90.0 хувиар үнэлж, баталгаажуулсан байна.

3.2.9 Тайлант онд бүрэн хэрэгжсэн техник, тоног төхөөрөмж худалдан авах нийт 3,560.3 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 58 төсөл, арга хэмжээнд аймаг болон

²² Захиалагч үе шатны ажилд техникийн хяналт тавих, гүйцэтгэлийн тэмдэглэл, ил далд ажлын болон тоног төхөөрөмжийн угсралт, туршилт, тохируулга хийсэн акт, санхүүжилтийн тооцоо, холбогдох бусад баримт бичгийг барилгын ажил гүйцэтгэх график, гэрээний дагуу барилгын үйл ажиллагаанд оролцогчтой хамтран хянаж, баталгаажуулахаас гадна техникийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий этгээдтэй хамтарсан үзлэг шалгалтыг урьдчилан сэргийлэх зорилгоор тухай бүр хийсэн байна.

²³ Төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэлийн санхүүжилтийн явц бүрд захиалагчийн техник, технологийн хяналтын тэмдэглэл, явцын тайлан, дүгнэлтийг тухай бүр гаргах

²⁴ 37.1.Барилгын ажлын захиалагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 37.1.5.барилгын ажлын үе шат бүрд зохиогчийн хяналт хийлгэж, хөндлөнгийн лабораторийн шинжилгээгээр материал, хийц, бүтээц, эдлэхүүний чанар, аюулгүй байдлын техникийн үзүүлэлтүүдийг тодорхойлуулж, холбогдох зардлыг хариуцах.

²⁵ Барилгын тухай хуулийн 38.1.4-т заасны дагуу зураг төсөл зохиогчтой гэрээ байгуулж, барилгын ажлын үе шатанд зохиогчийн техникийн хяналт хийлгэн дүгнэлт гаргуулж, илэрсэн зөрчлийг арилгуулах.

²⁶ Зохиогчийн хяналтыг барилга байгууламжийн байршил, онцлогоос хамааруулан дараах 3 хэлбэрээр гүйцэтгэнэ. 3.2.3.барилгын ажлын үе шат бүрд хяналт тавих

²⁷ Барилгын ажлын захиалагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:37.1.19.барилгын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, фото зургаар баримтжуулан ил, далд ажлын актыг баталгаажуулах

Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн сумдын ЗДТГ-ын ажлын хэсгүүд нь захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж, “Тоног төхөөрөмж хүлээн авсан акт”-аар баталгаажуулан хүлээж авсан байна.

3.3 Төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнг үнэлж бүртгэн, зориулалтын дагуу ашиглаж байна уу?

Тайлант онд ашиглалтад хүлээн авсан нийт 631.5 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 8 төсөл, арга хэмжээг бүртгэл, тайланд тусгаагүй байна.

3.3.1 Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2²⁸, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.8.30²⁹-д заасны дагуу хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээг ашиглагч байгууллага нь бүртгэлд тусгахаар зохицуулсан байдаг.

3.3.2 Аймгийн Орон нутгийн өмчийн газраас хөрөнгөд бүртгэх зөвшөөрөл олгосныг үндэслэн тайлант онд комиссын актаар хүлээж авсан 14,145.7 сая төгрөгийн 139 төсөл, арга хэмжээг ашиглагч байгууллагууд бүртгэл, тайланд бүрэн тусгасан байна.

3.3.3 Харин аймгийн болон Мандал, Сүхбаатар, Түшиг сумын орон нутгийн хөрөнгө оруулалтаар тайлант онд бүрэн хэрэгжиж, комиссын актаар ашиглалтад хүлээн авсан нийт 631.5 сая төгрөгийн гэрээний дүнтэй 8 төсөл, арга хэмжээг холбогдох байгууллагууд нь бүртгэл, тайланд тусгаагүй байна. Үүнийг дараах хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №7. Тайлант онд бүрэн хэрэгжиж, комиссын актаар ашиглалтад хүлээж авсан боловч бүртгэлд тусгаагүй төсөл, арга хэмжээний жагсаалт

/сая төгрөгөөр/

№	Аймаг, сумын нэр	Төсөл, арга хэмжээний нэр	Гэрээний дүн	Төсөл, арга хэмжээг бүртгэлд тусгах байгууллага
1	Сэлэнгэ	Зураг төсвийн зардал /Сүхбаатар сум Алтан намрын шим/	23.8	Сэлэнгэ аймгийн ЗДТГ
2	Сэлэнгэ	Халаалтын төвд зуух худалдан авах /Түшиг сум/	79.7	Түшиг сумын ЗДТГ
3	Сэлэнгэ	Зураг төсвийн зардал /Цагааннуур сум/	88.0	Цагааннуур сумын ЗДТГ
4	Сэлэнгэ	24, 27-р байрны дээврийн засвар /Сүхбаатар сум/	233.5	Орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй
5	Мандал	6-р багийн 44,46-р байруудын дээвэр засварын ажил	107.4	Орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй
6	Сүхбаатар	Сүхбаатар сумын төв талбайн Сүлд мод шинээр худалдан авах	20.0	Сүхбаатар сумын ЗДТГ
7	Сүхбаатар	Партизаны талбайн гэрэлтүүлгийн ажил	20.0	Сүхбаатар сумын ЗДТГ
8	Түшиг	Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт /Тайз/	59.1	Түшиг сумын Соёлын төв
Нийт дүн			631.5	

²⁸ Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, ...

²⁹ Эцсийн буюу бүрэн санхүүжилтийг авахад тухайн төсөл, арга хэмжээг ашиглагч байгууллага нь бүртгэлд тусгасныг нотлох баримт үйлдэж, баримт бичгийн иж бүрдэлд хавсаргах бөгөөд цахим системд баталгаажуулсан байна.

3.3.4 Аймаг болон сумдын төсвийн хөрөнгө оруулалтаар бүрэн хэрэгжсэн 148 төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг ашиглагч байгууллага болон иргэдтэй уулзаж, тулган баталгаажуулалт хийхэд 140 төсөл, арга хэмжээ нь зорилтот түвшиндээ бүрэн хүрч, зориулалтын дагуу ашиглагдаж байгаа бол дараах 8 төсөл, арга хэмжээнд зөрчил, дутагдал илэрсэн байна. Үүнд:

Аймгийн хөрөнгө оруулалт:



- “Билэг 5 дугаар сургуулийн гадна дулаан, цэвэр усны шугам /Мандал сум/” төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчээр шалгарсан “Алтайн үндэс констракшн” ХХК-тай 335.3 сая төгрөгөөр хэрэгжүүлэх гэрээ байгуулж, бүрэн хэрэгжүүлсэн боловч өвлийн улиралд шугам хөлдсөн, ариун цэврийн өрөөнд ус очдоггүй,



- “Бохирын машин худалдан авах /Цэнгэг ус ОНӨААТҮГ/” төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчээр шалгарсан “Сүнхүнгий ХХК” ХХК-тай 147.4 сая төгрөгөөр хэрэгжүүлэх гэрээ байгуулан, бүрэн хэрэгжүүлж тээврийн хэрэгслийг нийлүүлсэн боловч моторын доголдолтой, масло их зарцуулдаг, турбин дутуу ажиллаж, руллын аппарат дунд хаазанд залагддаг,



- “Аймгийн нэгдсэн музейн барилгын дотор засвар” төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчээр шалгарсан “Хүнхсэрвэн” ХХК-тай 96.0 сая төгрөгөөр хэрэгжүүлэх гэрээ байгуулсан боловч засварын ажил гүйцэтгэх явцад музейн үзмэр, соёлын өвүүдийг бохирдуулсан, ажлын даалгаварт тусгагдсан ажлыг дутуу гүйцэтгэсэн.

Сумдын хөрөнгө оруулалт:



- Мандал сумын “6-р багийн 44,46-р байруудын дээвэр засварын ажил” төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчээр шалгарсан “Баялаг тавиун уужим констракшн” ХХК-тай 107.4 сая төгрөгөөр хэрэгжүүлэх гэрээ байгуулж, бүрэн хэрэгжүүлсэн боловч өвлийн улиралд шугам хөлдсөн, ариун цэврийн өрөөнд ус очдоггүй,



- Мандал сумын “Хог нягтруулан тээвэрлэгч автомашин худалдан авах” төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчээр шалгарсан “Буянт суваргын булаг” ХХК-тай 111.5 сая төгрөгөөр хэрэгжүүлэх гэрээ байгуулж, бүрэн хэрэгжүүлсэн боловч өвлийн улиралд хог шахагч гидр бүрэн ажилладаггүй, даралт бага ирдэг,



- Сүхбаатар сумын “Онцгой төгөл” талбайн тохижилт хийх /Боргүвээ 5-р баг/” төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчээр шалгарсан “Сэлэнгэ-Ундрам” ХХК-тай 78.0 сая төгрөгөөр хэрэгжүүлэх гэрээ байгуулж, бүрэн хэрэгжүүлсэн боловч цементэн талбай, 3 сандал зэрэг хийгдсэн боловч тохижилтын ажил харьцангуй бага,



- Сүхбаатар сумын “Хүүхдэд ээлтэй цэцэрлэг дотоод орчин бүрдүүлэх /Сүхбаатар сум 6-р цэцэрлэг/” төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчээр шалгарсан “Болордарьяа” ХХК-тай 19.0 сая төгрөгөөр хэрэгжүүлэх гэрээ байгуулж, бүрэн хэрэгжүүлсэн боловч техникийн тодорхойлолтод Эрдэнэт хивс, хивсэнцэр гэж тусгагдсан боловч Хятад улсад үйлдвэрлэгдсэн хивсэнцэр нийлүүлсэн,



- Түшиг сумын “Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт /ТАЙЗ/” төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчээр шалгарсан “Хосмакс” ХХК-тай 59.1 сая төгрөгөөр хэрэгжүүлэх гэрээ байгуулсан боловч гэрэлтүүлгийн ажлуудыг дутуу хийж гүйцэтгэсэн байна.

Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

3.3.5 Иймд төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх ажлын гэрээний тусгай нөхцөлд заагдсаны дагуу ашиглагч байгууллагуудаас захиалагчид хүргүүлсэн дээрх доголдлыг арилгуулан, хэвийн ажиллах нөхцөлийг хангах шаардлагатай байна.

3.3.6 Тайлант онд хэрэгжүүлж дуусгахаар гэрээ байгуулсан нийт төсөл, арга хэмжээний 90.2 хувь нь төлөвлөсөн үр дүндээ хүрсэн байна. Тухайлбал:

- *Боловсролын салбарт 2,949.5 сая төгрөгийн гэрээний дүн бүхий 30 төсөл, арга хэмжээ нь боловсролын салбарт хэрэгжсэн бөгөөд сургууль, цэцэрлэгийн багш ажилчид нь зөөврийн компьютер, ухаалаг дэлгэц, өнгөт принтер зэрэг тоног төхөөрөмжөөр хангагдсан бол суралцагчдын аюулгүй байдлыг хамгаалах, боловсрол хүмүүжилд нь зориулагдах зөвлөн эдлэл, тоглоом, тавилга, сандал ширээ, гадна дотор хяналтын камераар хангагдсан байна.*
- *Эрүүл мэндийн салбарт 774.5 сая төгрөгийн гэрээний дүн бүхий 12 төсөл, арга хэмжээ хэрэгжсэн бөгөөд эрүүл мэндийн байгууллагуудын эмч, эмнэлгийн ажилтнуудыг ая тухтай ажиллах боломжийг нэмэгдүүлэх, стандарт шаардлага хангасан тоног төхөөрөмжөөр бүрэн хангасан, ард иргэдийн эрүүл мэндэд шаардлагатай тоног төхөөрөмжийг нийлүүлсэн, барилгын засварыг хийж гүйцэтгэсэн байна.*

3.3.9 Нийт гэрээ байгуулсан төсөл, арга хэмжээнээс хэрэгжээгүй болон дутуу хэрэгжсэн 16 төсөл, арга хэмжээг ангиллаар нь авч үзвэл:

- *Авто зам, дэд бүтцийн 1 төсөл, арга хэмжээ,*
- *Барилга, байгууламжийн 1 төсөл, арга хэмжээ,*
- *Зураг төсөв, зөвлөх үйлчилгээний 9 төсөл, арга хэмжээ,*
- *Их засвар, тохижилтын 2 төсөл, арга хэмжээ,*
- *Тоног төхөөрөмжийн 3 төсөл, арга хэмжээ байна.*

3.3.10 Үүнээс үзэхэд тайлант онд хэрэгжиж дуусаагүй төсөл, арга хэмжээний дийлэнх буюу 56.2 хувийг зураг төсөв, зөвлөх үйлчилгээний төсөл, арга хэмжээ эзэлж байгаа нь дараагийн жилүүдэд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний урьдчилсан нөхцөлийг бүрдүүлэх боломжийг бууруулсан байна.

ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ

Аудитаар нийт **7,852.0** сая төгрөгийн зөрчил илэрч, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

1. Албан шаардлага:

- Зураг, төсөв боловсруулах ажлын даалгаврыг боловсруулж, батлаагүй нийт **7,057.9** сая төгрөгийн өртөг бүхий 43 төсөл, арга хэмжээг аймаг, сумдын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн,
- Аймгийн ОНХО-аар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зураг төсөв, техникийн тодорхойлолт нь урьдчилан хийгдээгүй 2 төсөл, арга хэмжээ (*270.0 сая төгрөгийн төсөвт өртгийн давхцалыг хасаж тооцсон*)-г санхүүжүүлэхээр төсөвлөсөн,

Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

- Сүхбаатар сум нь тайлант онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн “Хүнсний агуулахын барилга барих” төсөл, арга хэмжээ (500.0 сая төгрөгийн төсөвт өртгийн давхцалыг хасаж тооцсон)-ний зураг, төсөвт магадлал хийлгэж баталгаажуулаагүй,
- Шаамар сум нь **23.8** сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Явган хүний замын зураг төсөв”-ийн худалдан авах ажиллагааг зохион байгуулалгүйгээр шууд гэрээ байгуулсан,
- Ерөө сум нь захиалагч сумын Засаг даргын баталсан бус Бугант тосгоны захирагчийн баталсан техникийн тодорхойлолтыг үндэслэн **35.0** сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Онцгой байдлын гал унтраах ангийн газар худалдан авах” төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг тухайлсан нэг оролцогч руу чиглэн зохион байгуулсан, худалдан авсан газрыг бүртгэл тайланд тусгаагүй,
- Аймгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан 2 төсөл арга хэмжээ (228.6 сая төгрөгийн төсөвт өртгийн давхцалыг хасаж тооцсон)-г хуваан, харьцуулалтын аргаар тендер шалгаруулсан,
- Мандал сумын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 2 төсөл, арга хэмжээний санхүүжилт болох **103.8** сая төгрөгийг зардлын эх үүсвэр хооронд гүйлгэн санхүүжүүлсэн,
- Нийт **631.5** сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 хөрөнгийг холбогдох байгууллагуудын бүртгэл, тайланд тусгаагүй байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 91.0 хувийг аймаг, сумдын хөгжлийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан төлөвлөсөн байна
- Шатны шатны захиалагч нь ОНХО-ын төсөл, арга хэмжээний зураг, төсөв боловсруулах ажлын даалгаврыг боловсруулж, батлаагүй байна.
- Зураг төсөв, техникийн тодорхойлолтыг боловсруулаагүйгээс шалтгаалан 4 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй байна.
- Тайлант онд тендер шалгаруулалттай холбоотой 6 аж ахуйн нэгжээс гаргасан өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна.
- Тайлант онд хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан 8,688.7 сая төгрөгийн гэрээний дүнтэй 16 төсөл, арга хэмжээ нь хэрэгжээгүй байна.
- Аймаг, сумдын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнүүдийн үе шат бүрд захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлж, комиссын актаар хүлээн авсан байна.
- Тайлант онд ашиглалтад хүлээн авсан нийт 631.5 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 8 төсөл, арга хэмжээг бүртгэл, тайланд тусгаагүй байна.

Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Аймаг, сумдын Засаг дарга нарт:

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тухайн онд санхүүжих дүнг хэрэгжих хугацаатай нь уялдуулан тэнцүү хуваарилж, санхүүжүүлэхээр төлөвлөх.
- Шат шатны ИТХ-аар баталсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуулийн хугацаанд нь зохион байгуулах замаар хэрэгжилтийг бүрэн хангуулах.
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн баталгааг банкны болон даатгалын байгууллагаар баталгаажуулсны үндсэн дээр гэрээ байгуулах.
- Бүрэн хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүдийг ашиглагч талын хэрэгцээг бүрэн хангах нөхцөлийг бүрдүүлэн, хэвийн бус ажилласан тохиолдолд гүйцэтгэгч байгууллагаар засварлуулах, гэрээний үүргийн хэрэгжилтийг хангуулах.


ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР

АУДИТОР



Б.БАТМӨНХ

Ц.ОТГОНБАЯР

С.БААСАНСҮРЭН

Ж.БАЯСГАЛАН

Р.ОТГОНЖАРГАЛ

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГААС ИРҮҮЛСЭН САНАЛ



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**

Аймгийн Засаг даргын Тамгын газрын 1 байр, Их суварга 505,
Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг, 43081
Утас: Факс: 7036-2223, Цахим шуудан: azdtg@selenge.gov.mn
Цахим хуудас: www.selenge.gov.mn

2026.05.11 № 01/531

танай _____-ны № _____

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

“Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тус тайлангийн төсөлд холбоотой санал байхгүй болно.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Ж.САЙНЦОГ

4320010308